



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/В1

Улаанбаатар хот

Хотын стандартын жишиг зураг
төсөл боловсруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10^{1.1}, 10^{1.2}, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах, орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2023 онд шинээр боловсруулах эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөлд шаардагдах зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2.Хотын стандартыг боловсруулахад шаардагдах 19,300,000 (Арван есөн сая гурван зуун мянга) төгрөгийг Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Хотын стандартын ажлын даалгавар боловсруулах, зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллагуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын хөгжлийн стандартын хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА


С.ТӨМӨРДУЛАМ

